Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Гүйцэтгэлийн зорилт №1.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах | - | - | - | - | | Тайлант хугацаанд 1."Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т боловсролын салбартай холбоотой зорилт, үйл ажиллагааны саналын төслийг боловсруулж, 2024.08.02-ны 2/241 тоот дугаартай албан бичгээр ЭЗХЯ-д хүргүүлсэн. "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27 өдрийн 21 дүгээр тогтоолоор батлагдсан /https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311/. 2. "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний боловсролын салбартай холбоотой арга хэмжээний саналыг боловсруулан Эдийн засаг, хөгжлийн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | яаманд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 1/1939 тоот албан бичгээр хүргүүлсэн. 3.Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 227 дугаар тогтоолоор "Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц" батлуулсан. 4.Хос хэлний сургалтыг тодорхойлж, "Үзэл баримтлал батлах тухай" Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор батлагдсан "Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-д тусгаж, бага боловсролын казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулав. 5. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны 222 дугаар тогтоолоор "Гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг боловсруулж батлуулсан. 6.УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн дүнд Засгийн газрын бүрэлдэхүүнд ажиллах Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам-ын УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтуудаар матриц гаргаж, шинилгээ хийж, "Хурдтай хөгжлийн төлөөх зориг хамтарсан Засгийн газрын гэрээ"-ний төсөлд тусгах дараах 4 багц саналыг хүргүүлж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын "Хамтарсан гэрээ" -нд тусгуулсан.<br>Хавсралт: 10 файл | | |
| 1.1.1 | 1.1.1. Засгийн газрын 2024-2028 оны | - | Батлагдсан хөтөлбөр | Мөрийн хөтөлбөрүүд | - | Хөтөлбөр УИХ-аар батлагдсан байна | "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т боловсролын салбарын зорилт, үйл ажиллагааны саналыг боловсруулж, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын салбарт хамаарах зорилт, үйл ажиллагааг холбогдох нэгжүүдтэй хамтран боловсруулж, хүргүүлнэ. | | | | | | нэгжүүдээс санал авч, нэгтгэн үет шаттай хэлэлцүүлэн эцэслэж, Төрийн нарийн бичгийн даргын 2024.08.02-ны 2/241 тоот дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Саналын төслийг боловсруулахдаа Засгийн газрын бүрэлдэхүүнд ажиллах Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам-ын УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтуудаар матриц гарган, шинжилгээ хийж, "Хурдтай хөгжлийн төлөөх зориг хамтарсан Засгийн газрын гэрээ"-нд тусгасан чиглэлийг үндэслэн боловсруулсан болно. "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27 өдрийн 21 дүгээр тогтоолоор батлагдсан /https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311/. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын салбараас дараах 4 бодлогын хүрээнд 41 зорилт, үйл ажиллагаа туссан. 1. Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол 2. Мэдлэг, чадвартай мэргэжилтэн 3. Багшлах хүний нөөц 4. Цахимжсан боловсрол Линк: https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.1.2 | 1.1.2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл | - | Батлагдсан төлөвлөгөө | Арга хэмжээний төсөл | - | Төлөвлөгөө Засгийн газраар батлагдсан байна | Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2024 оны 10 дугаар сарын 09-нд зохион зохион байгуулсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл боловсруулах сургалт, хэлэлцүүлэгт оролцож, өгсөн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Боловсролын салбарын арга хэмжээг холбогдох нэгж, байгууллагатай хамтран боловсруулж, хүргүүлнэ. | | | | | | зөвлөмжийн дагуу "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний боловсролын салбартай холбоотой арга хэмжээний саналыг боловсрууллаа. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний боловсролын салбараас тусгах санал боловсруулахдаа яамны холбогдох нэгжүүдтэй нийт 4 удаа уулзалт, хэлэлцүүлэг хийж, саналыг нь тусгасан. Түүнчлэн аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нартай 2024 оны 11 дүгээр сарын 22 болон 25-ны өдрүүдэд онлайн уулзалт хийж, төлөвлөгөөний төслийг танилцуулж, аймаг, нийслэлийн Засаг даргын ирэх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын салбартай холбоотой заавал тусгах арга хэмжээний чиглэлийг өглөө. Арга хэмжээний төлөвлөгөөнд боловсролын салбараас тусгах санал болон "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд тусгах саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд дараах албан бичгүүдээр хүргүүллээ. - Боловсролын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 1/1939 тоот албан бичиг - Боловсролын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 1/2458 дугаартай албан бичиг Хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"- | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ний төслийг 2024 оны 12 дугаар эхний хагаст багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ. Хавсралт: 4 файл | | |
| 1.1.3 | 1.1.3. Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ. | - | Засгийн газрын тогтоол | Судалгаа | Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргасан байна | - | Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 227 дугаар тогтоолоор "Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц" батлагдсан. Үндэсний болон олон улсын судалгаа, үндэслэн Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийг 10 түвшинтэйгээр боловсруулж, түвшин тус бүрийн тодорхойлогчийн төслийг тогтоолын төсөлд тусгасан болно. Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн төслийг боловсруулахад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр санхүүгийн дэмжлэг, ЮНЕСКО арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан болно. Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн түвшин тодорхойлогчийг нийтлэг мэргэжил болох нягтлан бодох бүртгэлийн мэргэжил болон шашны мэргэшлийг албан боловсролд дүйцүүлэх зорилгоор буддын гүн ухааны мэргэшлүүдийн жишээн дээр боловсруулан, туршиж, баталгаажуулсан. Туршилтын үед боловсролын сургалтын байгууллага, ажил олгогч, холбогдох яамд болон хувь судлаач гэх мэт олон талт оролцоог ханган хэлэлцүүлсэн. Энэхүү шаталсан бүтэц батлагдсанаар боловсрол, сургалт болон хөдөлмөрийн зах зээлийг нийцлийг хэрхэн хангах эх сурвалж болж, үр дүнд суурилсан боловсрол, сургалтын тогтолцоог бэхжүүлэх, хөгжүүлэх; үндэсний боловсрол, сургалтын тогтолцоо хэрэглэгч, иргэдэд аль түвшинд ямар мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмших, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авах боловсролын баримт бичиг, дараагийн түвшинд хэрхэн дэвшин суралцах нь илүү ойлгомжтой, тодорхой болж, боловсрол, сургалтын байгууллагын хувьд үндэсний хэмжээнд нэг стандарттай байх, сургалтын хөтөлбөр, суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлага нь хөдөлмөрийн зах зээлтэй хэрхэн уялдахыг тодорхойлох боломж бүрдэх; боловсрол, сургалтын байгууллагуудын уялдааг хангах, боловсрол, сургалтын босоо, хөндлөн холбоог бэхжүүлэх; төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, чадамж үндэсний хэмжээнд чанарын нэг ижил түвшинд болж, ажил олгогчид бүтээмжтэй ажилтантай болох, бизнесийн өсөлтөд эерэг нөлөөтэй болж; суралцагчид кредит хөрвүүлэн шатлан суралцах боломжтой болно.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.1.4 | 1.1.4. Хос хэлний талаар баримтлах чиглэл батлуулна. | - | Чиглэл | Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн судалгаа, хос хэлний сургалтын арга зүй | Судалгаа хийсэн байна | Сайдын тушаалаар батлагдсан байна | 1. Хос хэлний сургалтын талаар Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн "Үзэл баримтлал батлах тухай" 176 дугаар тогтоолоор батлагдсан "Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-д тусган батлууллаа. Тус үзэл баримтлалд "3.Сургалтын хөтөлбөр, түүний бүтэц,боловсруулахад тавих шаардлага" хэсэгт "Өөр хэл бүхий үндэстний цөөнхийн болон олон соёлт гэр бүлтэй суралцагчийн сургалтыг агуулга болон хэлийг интеграцчилан заах арга зүй (АХИС)-г баримталж зохион байгуулна" гэж заасан. Мөн хос хэлний боловсрол гэж хоёр буюу түүнээс дээш хэлээр сургалтын үйл ажиллагаа явуулахыг дэмжсэн | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсролын нэг төрөл гэж тодорхойлж өгсөн. 2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 7.3-д “Энэ хуулийн 7.2-т заасан суралцагч Монгол хэлний тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу хос хэлний хөтөлбөрөөр хичээллэх бөгөөд хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн зохицуулалттай. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д үндэслэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах төлөвлөгөөний төсөл боловсруулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Төлөвлөгөө, зардал батлах тухай" 2024 оны А/317 дугаар тушаалаар батлууллаа. Тус төлөвлөгөөний дагуу бага боловсролын казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийн төсөл боловсруулав. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнуудын боловсруулсан казах, тува хэлний сургалтын хөтөлбөртэй танилцах зорилготой уулзалтыг БНБТГ, ЕБГ, ЦБГ, СӨБХ-ийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулж, сайжруулан Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын 3 сургуульд туршиж байна. 3. Хос хэлний талаар баримтлах чиглэлийн төслийг боловсруулж, Баян-Өлгий аймгийн 6 сургуульд туршин үр дүнг тооцсон. Чиглэлийг Боловсролын сайдын тушаалаар батлахыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зөвлөмж хүлээж | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна.<br>Хавсралт: 4 файл | | |
| 1.1.5 | 1.1.5. “Гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ыг Засгийн газраар хэлэлцүүлсэн байна. | - | Засгийн газрын тогтоол | Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн хуралдааны 22 дугаар хурлын тэмдэглэл | Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарсан байна. | - | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит хуралдаанаар "Гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын сургалтын байгууллага болон насан туршийн боловсролын байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг хэлэлцэж, 222 дугаар тогтоолоор баталсан. Журмын төсөл боловсруулах ажлын хүрээнд 2023 онд 16 улсын 26 төвийн 43 багш, 130 эцэг эх, асран хамгаалагч хамрагдаж, хилийн чанадад дахь монгол хэл, соёлын сургалт, үйл ажиллагааны нөхцөл байдлын судалгааг хийсэн болно. Мөн журмын төсөлд Сангийн яам, Гадаад харилцааны яам, Соёлын яамны саналыг авч тусгасан. 2023-2024 оны хичээлийн жилийн байдлаар гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын сургалтын 1 байгууллага болох Бүгд Найрамдах Солонгос Улс дахь төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль нь үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хууль тогтоомжийн дагуу хувьсах зардлаар санхүүжиж байна. 2023-2024 оны хичээлийн жилд уг сургуульд 317 монгол хүүхдэд 12 бүлгээр хичээллэж, ерөнхий боловсрол эзэмшиж байна. ХБНГУ, АНУ, Канад, Швейцар, БНСУ зэрэг 16 улсад нийт 6000 гаруй хүүхдийг хамруулсан 59 монгол хэл, соёлын төв нь иргэдийн санаачилга дээр түшиглэн үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр төвүүд нь сургууль, цэцэрлэг, төв, зуслан зэрэг нэршилтэйгээр | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | монгол хэл, түүх, дуу хөгжим, бүжиг, шатар зэрэг чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулж байна. 2023-2024 оны хичээлийн жилийн байдлаар гадаад улсад Насан туршийн суралцахуйн төв одоогоор байгуулагдаагүй байна. Тогтоол батлагдсанаар гадаад улсад амьдарч буй Монгол Улсын харьяат хүүхдүүд монгол хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалаа суралцах, өвлөх, түгээн дэлгэрүүлэх, монгол хүний хөгжлийг дэмжих, Боловсролын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чухал алхам болох юм. Тогтоолын хэрэгжилтийг чиг үүргийн дагуу Боловсролын ерөнхий газар ханган ажиллаж байна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.1.6 | Хамтарсан Засгийн газрын "ХУРДТАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ" гэрээний төсөлд боловсролын салбараас тусгах зорилтыг боловсруулна. | - | Гэрээнд тусгах санал | Намуудын мөрийн хөтөлбөр | - | Хамтарсан гэрээний төсөлд боловсролын салбараас тусгах зорилтыг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна | УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн дүнд Засгийн газрын бүрэлдэхүүнд ажиллах Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам-ын УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтуудаар матриц гарган, шинжилгээ хийж, "Хурдтай хөгжлийн төлөөх зориг хамтарсан Засгийн газрын гэрээ"-ний төсөлд тусгах дараах 4 багц саналыг хүргүүлж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын "Хамтарсан гэрээ" боловсруулах ажлын хэсэгт ажиллалаа. - ТЭГШ ХАМРУУЛСАН БОЛОВСРОЛ - СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, СУРАХ БИЧИГ, ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ - БАГШЛАХ ХҮНИЙ НӨӨЦ, УР ЧАДВАР - МЭДЛЭГ ЧАДВАРТАЙ ТӨГСӨГЧИД - | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | БОЛОВСРОЛЫН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ - ЦАХИМЖСАН БОЛОВСРОЛ<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.2. | Гүйцэтгэлийн зорилт №1.2. Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | - | - | - | - | | Тайлант хугацаанд 1.Монгол Улсын Засгийн газраас “Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц”-ыг 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын хаврын чуулганаар хэлэлцүүлж, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр соёрхон батлуулсан. Олон улсын конвенцыг баталсанаас хойш соёрхон баталсан тухай нот бичгийг 3 сарын хугацаанд хадгалан ЮНЕСКО-д өргөн байрьдаг протоколын дагуу Парис дахь Байнгын төлөөлөгчийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр өргөн барьсан бөгөөд ЮНЕСКО-ийн вэбсайтад манай улс конвенцод нэгдсэн жагсаалтад орсон. 2.БШУ-ны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/182 дугаар тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас бусад боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгчийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуульд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журам” батлуулсан.<br>Хавсралт: 3 файл | 100% | 100 % |
| 1.2.1 | 1.2.1. Дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн | - | Хуулийн төсөл | Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23- | Хуулийн төслийг Улсын их хурлын чуулганаар | - | Монгол Улсын Засгийн газраас “Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц”-ыг 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн. 2019 оны 11 | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зөвшөөрөх тухай дэлхийн конвенцод нэгдэх хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ. | | | ны өдрийн хуралдааны 33 дугаар хуралдааны тэмдэглэл | хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна | | дүгээр сард ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 40 дүгээр чуулганаар батлагдаж, эхний 20 орон нэгдсэн орсноор 2023 оны 03 дугаар сарын 05-нд хүчин төгөлдөр болсон “Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц” нь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас дээд боловсролыг салбарыг хамарсан анхны дэлхийн хэмжээний гэрээ юм. Энэхүү конвенц нь нэгдэн орсон улс орнуудын их, дээд сургуулиудын боловсрол, сургалтын үр дүн, зэрэг, цолыг ил тод, шударгаар хүлээн зөвшөөрөх, суралцагчдад бусад орны их, дээд сургуулиудад үргэлжлүүлэн суралцах, хөдөлмөр эрхлэх, зайн хэлбэрээр суралцаж, эзэмшсэн мэргэшлээ хүлээн зөвшөөрүүлэх боломжийг олгодог. Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс дэлхийн улс орнуудтай дээд боловсролын салбарт хамтран ажиллах, бүс нутаг хоорондын инновацыг дэмжих, дээд боловсролын салбар дахь олон улсын харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монголын дээд боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхэд хувь нэмрээ оруулахаас гадна дээд боловсролын салбарт чанарын баталгаажуулалтын тогтолцоо, соёлыг төлөвшүүлж, чанарын баталгаажуулалтын найдвартай байдал, уялдаа холбоо, чадавхыг бэхжүүлэх боломж бүрдэж байна. Конвенц 2024 оны Улсын Их Хурлын хаврын чуулганаар хэлэлцүүлэгдэж 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр соёрхон батлагдсан. Олон | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | улсын конвенцыг баталсанаас хойш соёрхон баталсан тухай нот бичгийг 3 сарын хугацаанд хадгалан ЮНЕСКО-д өргөн байрьдаг протоколын дагуу Парис дахь Байнгын төлөөлөгчийн газраас 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр өргөн барьсан бөгөөд ЮНЕСКО-ийн вэбсайтад манай улс конвенцод нэгдсэн жагсаалтад орсон болно. Линк: https://www.unesco.org/en/legal-affairs/global-convention-recognition-qualifications-concerning-higher-ed<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.2.2 | 1.2.2. Ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журам боловсруулж, батлуулна. | - | Ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журам | - | Ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журмыг сайдын тушаалаар батлуулсан байна. | - | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/182 дугаар тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас бусад боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгчийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуульд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журам" батлагдсан. Журмын төсөлд Төрийн албаны зөвлөлийн саналыг тусгасан. Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн харьяа нутаг дэвсгэр дэх төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө” гэж заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бусад боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгчийн албан тушаалд тавих тусгай шаардлагад заасан хугацааг энэхүү журамд заасан жилтэй дүйцүүлэн тооцож, үүнтэй холбоотой харилцааг зохицуулна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.3. | Гүйцэтгэлийн зорилт №1.3. Боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл боловсруулах, батлуулах, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төсөл боловсруулах, салбар хоорондын уялдааг бодлогын удирдамжаар хангах, боловсролын чанарын | - | - | - | - | | Тайлант хугацаанд 1/ЗГ-ын 2024.04.24-ний 176-р тогтоолоор "Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-ыг, 2/Сайдын тушаал: 1. А/175-р тушаалаар "Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэл"-ийг, 3/ 2024.06.26-ны өдрийн сургалтын хөтөлбөр шинэчлэх, тохирцыг шалгах, хэрэгжүүлэх тухай "Төлөвлөгөө, зардал батлах тухай" А/317-р тушаалыг, 4/ 2024.09.02-ны А64 дүгээр тушаалаар “Багшлах эрхийн гэрчилгээ олгох болон үүнтэй холбогдох үйл ажиллагааны журам”-г батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлсэн тус тус батлуулсан.5/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд боловсрол, шинжлэх ухааны салбараас тусгуулах саналыг боловсруулж, 2023.01.15-ны өдрийн 1а/168-р албан бичгээр хүргүүлсэн. Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө УИХ-ын 2024.10.18-ны өдрийн 35-р тогтоолоор батлагдсан.6/АХБ-ны буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх "Шинжлэх ухаан, технологи, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр боловсролын салбарт ЕБС-ийн инновац, хамтын ажиллагааг дэмжих" төслийн Concept Note-ыг батлуулсан.7/Боловсролын салбарын үр | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үнэлгээ болон насан туршдаа суралцахуйн тогтолцоог хөгжүүлж бүх түвшний боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын чиглэл боловсруулах | | | | | | дүнд суурилсан зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар техник туслалцааны төслийн хүрээнд судалгаа хийж, төслийн санал боловсруулж АХБ 2025-2028 онд Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги болон "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөлд тусгасан.8/Дэлхийн банкны “Системийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дахь шатны хөтөлбөрийн санал, төсвийн төсөөллийг баталгаажуулан Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагад хүргүүлсэн. 8/Монгол Улсын боловсролыг дэмжих “Олон нийтийн бүлэг” (LEG)-ийн дээд түвшний уулзалтыг 2024.12.06-нд зохион байгууллаа. 9/Багшийн чадамжийн стандарт боловсруулах ажлыг эхлүүлж, холбогдох судалгааг хийсэн.10/2025-2028 онд багшийг гадаад, дотоодод бэлтгэх төлөвлөлтийг хийсэн.11/ЗГ-ын 2019 оны “Журам батлах тухай” 5-р тогтоолын 3-р хавсралтад өөрчлөлт оруулах саналыг боловсруулж хүргүүлсэн.<br>Хавсралт: 11 файл | | |
| 1.3.1 | 1.3.1. Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэлийг батлуулна. | - | Тэргүүлэх чиглэл | Судалгаа | Тэргүүлэх чиглэлийг боловсруулж, хэлэлцүүлж, батлуулсан байна | - | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024.04.16-ны өдрийн А/175 дугаар тушаалаар "Насан туршийн суралцахуйн тэргүүлэх чиглэл”-ийг батлууллаа. Тэргүүлэх чиглэлийг төслийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагаар хэлэлцүүлж, ЮНЕСКО-гийн Насан туршийн хүрээлэнгээс арга зүйн дэмжлэг авч, саналыг нь төсөлд тусгасан. Чиглэл | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэгжсэнээр сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын насны хүн амын боловсролд хамрагдалтад ахиц гарч, боловсрол, сургалтад хамрагдсан насанд хүрсэн иргэдийн эзлэх жин нэмэгдэж, эзэмшсэн мэдлэг, чадвар, чадамжаа хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулсан 25-аас дээш насны хүн амын эзлэх жин нэмэгдэж, насан туршийн суралцахуйн төвийн удирдлага, ажилтнуудын ажил мэргэжлийн стандарт, ажил үүргийн эрх зүйн орчин бүрдэж, төвийн үйл ажиллагаанд оролцсон орон нутгийн иргэдийн эзлэх жин болон 1 иргэнд ногдох боловсрол, сургалтад зарцуулсан санхүүжилтийн хэмжээ нэмэгдэхээс гадна насан турштаа суралцахуйн удирдлага, мэдээллийн системтэй болох юм.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.3.2 | 1.3.2. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлнэ. | - | Үзэл баримтлалыг баталсан тогтоол | Судалгаа, хэлэлцүүлэг | Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарсан байна | - | Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг Боловсролын ерөнхий хуулийн 23.1, 23.4-д заасан Боловсролын үндэсний зөвлөлийн анхдугаар хуралдаанаар 2024 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр хэлэлцүүллээ. Хуралдаанд Боловсролын үндэсний зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Боловсролын үндэсний зөвлөлийн дэд дарга, Боловсрол, шинжлэх ухааны сайд нар оролцож, 72.3 хувийн ирцтэй хуралдав. Боловсролын үндэсний зөвлөлийн хуралдаанаар уг үзэл баримтлалын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх шийдвэр гаргав. Тус үзэл баримтлалын төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбогдох баримт бичгийн хамт Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 1а/1642 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэв. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, "Үзэл баримтлал батлах тухай" 176 дугаар тогтоолоор баталсан.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.3.3 | 1.3.3. Сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэх төлөвлөгөөний төсөл боловсруулна. | - | Хөтөлбөр шинэчлэх төлөвлөгөө | Үзэл баримтлал | Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар баталсан байна | - | Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн "Үзэл баримтлал батлах тухай" 176 дугаар тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д үндэслэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах төлөвлөгөөний төсөл боловсруулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн "Төлөвлөгөө, зардал батлах тухай" А/317 дугаар тушаалаар батлуулллаа. Баталсан тушаалын дагуу сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-д үндэслэн холбогдох мэргэжлийн байгууллага, сургалтын байгууллага, судлаач, эрдэмтэн, багш нартай хамтран шинэчлэх, тохирцыг шалгах үйл ажиллагааг 2024-2029 онд хэрэгжүүлнэ. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын бага ангийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, тохирцыг шалгах | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажлыг 2024-2025 оны хичээлийн жилд эхлүүллээ. Шинэчилсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт нийцүүлэн суралцагчийн дасгал ажлын дэвтэр, багшийн ном, цахим сургалтын сан, гарын авлага боловсруулах, тэдгээрийн тохирцыг шалгаж, сайжруулах ажлыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн хариуцан гүйцэтгэж байна. Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв хамтран шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн дагуу үнэлгээний шалгуур, зөвлөмж боловсруулах, даалгаврын сан шинэчлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдлагад зориулсан сургалт зохион байгуулах, шинэчилсэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх бэлтгэл хангах ажлыг хийж гүйцэтгэж байна.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.3.4 | 1.3.4. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд боловсрол, шинжлэх ухааны асуудлаар тусгуулах санал боловсруулна. | - | Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгах санал | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 12 асуудал тусгагдсан. | Төлөвлөгөөний төсөлд тусгуулах саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн байна | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан Монгол Улсын хөгжлийн 2025 оны | Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” А/592 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг батлуулсан. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд боловсрол, шинжлэх ухааны салбараас тусгуулах саналыг БШУЯ-ны 2023 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1а/168 дугаартай албан бичгээр дийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Боловсрол, шинжлэх ухааны салбараас тусгуулах төсөл, арга хэмжээний талаар танилцуулга, тайлбар зэрэг мэдээллийг | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөөнд тусгах саналыг шинэчлэн боловсруулж, хүргүүлсэн байна | тогтмол хүргүүлж, дийн засаг, хөгжлийн яамнаас зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэгт оролцож тодруулга, мэдээлэл өгч ажиллалаа. "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг үндэслэн Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд боловсролын салбараас тусгах саналд өөрчлөлт оруулан Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 1/1108 албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, УИХ-ын байнгын хороодын хурлаар хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллаа. УИХ-ын чуулганы 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-г баталсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17142247261431<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.3.5 | 1.3.5. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих Боловсрол салбарт инновацыг дэмжих төслийн дизайн боловсруулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | - | Төслийн дизайн | - | Төслийн дизайн боловсруулахад дэмжлэг үзүүлсэн байна | Төслийн дизайн боловсруулсан байна | Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх "Шинжлэх ухаан, технологи, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр боловсролын салбарт ЕБС-ийн инноваци, хамтын ажиллагааг дэмжих" төслийн үзэл баримтлал /Concept Note/ 2024 оны 5 дугаар сард батлагдсан. Төслийн дизайн боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны баг 5, 9, 12 дугаар сард Монгол Улсад томилотоор ажиллаж, төсөл хэрэгжүүлэх сургуулиудыг сонгох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Төслийг ерөнхий боловсролын 109, 149, 159, 42 дугаар сургуулиудад хэрэгжүүлэхээр урьдчилсан байдлаар сонгоод байна. х | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хавсралт: 3 файл | | |
| 1.3.6 | 1.3.6. Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжих Үр дүнд суурилсан зээлийн хөтөлбөрийн санал боловсруулна. | - | Дээд боловсролыг хөгжүүлэх төслийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгана | - | - | Үр дүнд суурилсан зээлийн хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх бэлтгэл хангах, нөхцөл байдлын судалгаа хийж, санал боловсруулсан байна | Боловсролын салбарын үр дүнд суурилсан зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар техник туслалцааны төслийн хүрээнд судалгаа хийж, төслийн санал боловсруулж байна. Азийн Хөгжлийн Банк 2025-2028 онд Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегит Боловсролын салбарын үр дүнд суурилсан зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Мөн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөлд 2026 оноос хэрэгжүүлэхээр тусгасан.<br>Хавсралт: 2 файл | 100% | 100 % |
| 1.3.7 | 1.3.7. Боловсролын дэлхий нийтийн түншлэлийн “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төсөлд өргөдөл гаргана. | - | Системийн чадавх бэхжүүлэх төсөл | Салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ, Төслийн санал | Салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, салбарын тэргүүлэх чиглэлээ тодорхойлсон байна | Боловсролын дэлхий нийтийн түншлэлийн “Системийн чадавх бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн төсөлд өргөдөл гаргасан байна. | Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагын журмын дагуу тусламжийн санхүүжилтийг хамтран удирдах агентлагаар сонгогдсон Дэлхийн банк болон Боловсролын яамны ажлын хэсгээс боловсруулсан “Системийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дахь шатны хөтөлбөрийн санал, төсвийн төсөөллийг баталгаажуулан Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл байгууллагад хүргүүлэхээр Боловсролын яамны 2024.12.05-ны өдрийн 1/2524 дугаартай албан бичгээр Монгол Улс дахь Япон Улсын Элчийн сайдын яаманд хүргүүлэв. Монгол Улсын боловсролыг дэмжих “Олон нийтийн бүлэг”-ийн дээд хэмжээний уулзалтыг 2024 оны 12 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулж, энэхүү төслийн саналыг танилцууллаа. | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хавсралт: 3 файл | | |
| 1.3.8 | 1.3.8. Боловсролын донор болон хөгжлийн байгууллагын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангана. | - | Боловсролыг дэмжигч түншлэгчдийн хуралдаан | Боловсролыг дэмжигч түншлэгчдийн багийн ажлын удирдамж | Боловсролын салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг хэлэлцүүлсэн байна. | - | Олон улсын хөгжлийн болон донор байгууллагаас боловсролын салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг уялдуулах, үр дүнтэй хамтын ажиллагаа, түншлэлийг зохицуулах механизм болох Монгол Улсын боловсролыг дэмжих “Олон нийтийн бүлэг” (LEG)-ийн дээд түвшний уулзалтыг 12 дугаар сарын 6-ны өдөр амжилттай зохион байгууллаа. Дээд хэмжээний уулзалтаас EQUAL төслийн хугацааг 6 сараар сунгах, Системийн чадавхыг сайжруулах төслийн II шатны саналыг GPE-д гаргахаар тогтов. Мөн "LEG communication and coordination plan"-г хэлэлцүүлж дэмжлээ.<br>Хавсралт: 7 файл | 100% | 100 % |
| 1.3.9 | 1.3.10. Хөрвөх болон багшлах эрх олгох сургалтын талаарх асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулна. | - | Засгийн газрын тэмдэглэл | Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 33 дугаар тэмдэглэл | - | Асуудлыг Засгийн газарт танилцуулсан байна. | Боловсролын сайдын 2024.09.02-ны өдрийн А/64 дүгээр тушаалаар “Багшлах эрхийн гэрчилгээ олгох болон үүнтэй холбогдох үйл ажиллагааны журам” батлагдан, Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд 2024.09.12-ны өдөр 6923 дугаартай бүртгүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанд "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зарим асуудал" танилцуулагдаж, 33 дугаар тэмдэглэл гарсан. Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны А/64 дүгээр тушаалаар батлагдсан Багшийн мэргэжлээс бусад мэргэжилтэй иргэнд багшлах эрх олгох олгохтой холбоотой үйл ажиллагааг зохицуулах журам Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд | 90% | 90 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр 1932 дугаарт бүртгэгдэн хэрэгжиж байгаа. Журмын хэрэгжилтийг Боловсролын ерөнхий газар хангаж ажиллаж байгаа. Тайлант хугацаанд багшийн хөтөлбөрөөр сургалт явуулж байгаа багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагуудын боловсруулсан хувилбарт сургалтын хөтөлбөрт журамд заасны дагуу Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс дүгнэлт гаргах үйл ажиллагаа явагдаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 28-ны байдлаар багш бэлтгэдэг МУИС, МУБИС, СЭЗИС, ОУУБИС, Отгонтэнгэр их сургууль зэрэг 5 их сургуулийн хувилбарт сургалтын хөтөлбөрийн дүгнэлт гарч, сургалтын бүртгэлээ эхлүүлээд байна. 2024.12.02-ны байдлаар 169 иргэн бүртгүүлээд байна. Сургалтууд хагас жил тутамд зохион байгуулагдана. 2024-2025 оны хичээлийн жилд багш бэлтгэдэг 5 их сургууль нийт 59 хөтөлбөрөөр хөрвөх сургалт явуулахаар систем бүртгэгдсэн бөгөөд нийт 236 оюутан суралцаж байна. Багш бэлтгэх хөрвөх сургалтын хувьд Хөрвөх сургалтын үйл явцын талаар МУБИС-ийн хөрвөх сургалтад хамрагдаж байгаа багш нартай 2024.10.30-ны өдөр уулзалт зохион байгуулж, санал солилцсон. Сургалтуудын явц, үр дүнд үндэслэн асуудлыг Засгийн газарт танилцуулахаар тогтсон.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.3.10 | 1.3.11. Багшийн чадамжийн стандартын | - | Стандартын төсөл | - | - | Судалгаа хийгдсэн байна | Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.09.26-ны өдрийн А/50 дугаар тушаалаар "Багшийн чадамжийн стандарт боловсруулах ажлын | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төслийг боловсруулахад шаардлагатай судалгаа хийнэ. | | | | | | хэсгийн бүрэлдэхүүн" батлагдсан. Ажлын хэсгийн хүрээнд Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн багшийн чадамжийн хүрээний судалгаа хийж, багшийн чадамжийн хүрээний төслийг боловсруулсан. Стандартын төсөл боловсруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 2/2482 дугаартай албан бичгээр Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд судалгаа, стандартын төслийг ирүүлэх чиглэл хүргүүлсэн. Стандартын төслийн эхний хувилбарыг 2024 оны 12 дугаар сард багтаан боловсруулахаар ажиллаж байна.<br>Хавсралт: 3 файл | | |
| 1.3.11 | 1.3.12. Багшлах хүний нөөцийг гадаад, дотоодод бэлтгэх төлөвлөлтийг хийнэ. | - | Төлөвлөгөөний төсөл | - | - | Төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна | "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ийн төсөлд боловсролын салбараас тусгах арга хэмжээний саналд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн "2.2.3.4.Багшлах хүний нөөцийг чадавхжуулж, цэцэрлэгийн 10000 багш, бага ангийн 2000 багш, ерөнхий боловсролын сургуулийн 11000 багш, англи хэлний 2000 багш, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын 2000 багшийг гадаад, дотоодод бэлтгэнэ" туссан зорилтыг хэрэгжүүлэхээр зорилгоор дараах арга хэмжээний 2025-2028 оны төлөвлөлтийг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Цэцэрлэгийн бүлгийн, хөгжмийн, биеийн тамирын, тусгай хэрэгцээт боловсролын 10,000 багш; 2. Сургуулийн өмнөх, ерөнхий | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
